



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠑᠙᠑᠑ оны ᠐᠔ сарын ᠐᠖ өдөр

Дугаар А1᠒8

Мандалговь

Аймгийн Шагайн холбооны “Мялаалга харваа”-ны
үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.6, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.4.1.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.1.1, 2.2.1.1.4 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 06-ний өдрийн 06 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Үндэсний уламжлалт спортыг өвлүүлэн уламжлуулах чиглэлээр Спортын холбоодтой хамтран ажиллах хүрээнд Монголын Шагайн холбооны Улсын аварга шалгаруулах 31 дэх удаагийн тэмцээний түрүү Монгол Улсын мэргэн Ц.Отгонбаяр ахлагчтай “Бүрд” багийн “Мялаалга харваа”-ны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 3,000,000 (Гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100357